

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 06 сарын 11-ны
дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 05 сарын 21-ны өдөр

Дугаар А/225/А/153/А/85

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.13 дахь заалт, Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга (цагдаагийн хурандаа Ж.Буянбат)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Мягмар), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат), Улсын ерөнхий прокурорын орлогч (төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны А/216,422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Гэмтлийн зэрэг тогтоох журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны 05 дугаар сарын 21 ны өдрийн 4/225А/33 / А/85 дугаар тушаалын хавсралт

ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД УЧИРСАН ХОХИРЛЫН ЗЭРЭГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох шүүх эмнэлгийн шинжилгээ (цаашид “шинжилгээ” гэх) хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг шүүх шинжилгээний байгууллагын шинжээч болон шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээд /цаашид “шинжээч” гэх/ шинжилгээ хийхэд дагаж мөрдөнө.

1.3. Шинжээч нь шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэргийг хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол гэж ангилах бөгөөд дараах шинжийг харгалзан эрүүл мэндэд учирсан хохирлын зэргийг тогтооно:

- 1.4.1. амь насанд аюултай эсэх;
- 1.4.2. эрүүл мэнд сарниулсан хугацаа;
- 1.4.3. гэмтлээс үүссэн үлдэц уршиг;
- 1.4.4. хөдөлмөрийн чадвар алдалт.

1.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шинжээч хүний биед шинжилгээ хийхдээ, прокурорын зөвшөөрөл, эрх бүхий албан тушаалтны хүсэлтийг үндэслэн, дүгнэлт гаргана.

Хоёр. Шинжилгээ хийх зарчим

2.1. Шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, 33.2 дэх хэсэг, 41, 42, 46, 47 дугаар зүйлийг тус тус баримтална.

2.2. Шинжилгээ хийлгэх этгээд шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүрэлцэн ирэх боломжгүй тохиолдолд эмнэлгийн баримт бичиг, шаардлагатай бусад баримтыг үндэслэн дүгнэлт гаргаж болно.

2.3. Эмнэлгийн баримт бичиг нь эх хувь, эсхүл баталгаажсан хуулбар байна.

2.4. Эмнэлгийн баримт бичигт гэмтлийн шинж, эмнэл зүйн явц, шинжилгээний үр дүн, онош бүрэн тусгагдсан, эмчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан өвчтөний

түүх, амбулаториор эмчлүүлэгсдийн карт, хяналтын карт, яаралтай тусламжийн хуудас, лабораторийн болон багажийн шинжилгээний зураг, бичлэг, тэдгээрийг агуулсан тусгай тээгч байна.

2.5.Шинжилгээний байгууллагад дүгнэлт гаргуулахаар ирүүлэх эмнэлгийн баримт бичгийн үнэн зөвийг шинжээч томилсон эрх бүхий этгээд болон шинжлүүлэгч хүн хариуцна.

2.6.Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэргийг дараах зарчмыг баримтлан тогтооно:

2.6.1.шинжилгээ хийхдээ тухайн гэмтлийн төрөл, хэлбэр, хэмжээ, өнгө, байрлал, онцлог зэргийг шинжилгээний баримт бичигт заавал тусган оношийг бичих;

2.6.2.хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэргийг үнэлэх шалгуур шинжээс нэг илэрч байвал түүгээр хэрэв олон шалгуур шинж илэрч байвал хамгийн хүнд шалгуур шинжээр;

2.6.3.шинжилгээ хийлгэх этгээд нэг цаг хугацаанд биедээ хэд, хэдэн гэмтэл авсан бол шаардлагатай тохиолдолд гэмтэл тус бүрээр;

2.6.4.хэрэв гэмтэл нэг нэгэндээ харилцан нөлөөлж, шинжилгээ хийлгэх этгээдийн биеийн байдлыг хүндрүүлсэн бол гэмтлийг бүрдэл байдлаар;

2.6.5.шинжилгээ хийлгэх этгээдийн биед илэрсэн хэд, хэдэн гэмтлийг өөр өөр цаг хугацаанд үүссэн гэж үзвэл гэмтэл тус бүрд үүссэн хугацаа, үүсгэсэн хүчин зүйлээр;

2.6.6.мэс ажилбар, мэс засал буруу, эсхүл шаардлагагүй тохиолдолд хийгдсэн бол энэ журмын дагуу;

2.6.7.суурь архаг өвчтэй болон түүний үлдэцийг сэдрээсэн, хүндрүүлж эмчилгээ удаан хугацаагаар хийгдэх шаардлага гарсан тохиолдолд архаг өвчин, гэмтлийн алинаас нь үйл ажиллагааны алдагдал үүсч буйг ялган оношилж, зөвхөн гэмтлийн улмаас үүссэн үйл ажиллагааны алдагдлаар;

2.6.8.урьд нь үүссэн гэмтлийн улмаас эрхтэний үйл ажиллагаа хэсэгчлэн эсхүл бүрмөсөн алдагдсан тохиолдолд эрүүл мэндэд хэрхэн нөлөөлснөөр;

2.6.9.биеийн хос эрхтэн гэмтсэн тохиолдолд зөвхөн гэмтсэн эрхтэн, гэмтсэн биеийн хэсгийн үйл ажиллагааг үнэлэх;

2.6.10.гэмтлийн хүндрэл, амь тэнссэн байдал нь гэмтэлтэй шууд шалтгаант холбоотой, тохиолдлын шинжгүй байх.

2.7.Дараах тохиолдолд хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоохгүй:

2.7.1.шинжилгээ хийлгэх этгээдийн биед оношилгоо, эмчилгээний зорилгоор техникийн хувьд зөв хийгдсэн гардан үйлдэл, мэс ажилбар, мэс засалд;

2.7.2.урьд нь өвчилж байсан өвчин, хувь хүний өвөрмөц онцлогтой холбоотойгоор биеийн байдал хүндэрсэн, үйл ажиллагааны алдагдал үүссэн бол;

2.7.3.шинжилгээ хийлгэх этгээдийн эрүүл мэнд сарниагүй, ерөнхий хөдөлмөрийн чадвар тогтонги алдагдаагүй, ямар нэг зовуурь, эмнэл зүйн шинж илрээгүй, биеийн нийт гадаргуугийн 1 хувиас илүүгүй хэмжээтэй, зулгаралт, цус хуралт, зөөлөн эдийн няцралын үед.

2.8.Биеийн гадаргуугийн нэг хувьд хүрэхгүй зовуурь эмнэл зүйн шинж илэрсэн нүүр хэсгийн зөөлөн эдийн гэмтэл нь энэхүү журмын 2.7.3-т заасан нөхцөлд хамаарахгүй.

2.9.Шинжилгээ хийлгэх этгээд эмнэлгийн тусламж авснаар биеийн байдал сайжирсан нь эрүүл мэндэд учирсан хохирлыг хөнгөрүүлэх үндэслэл болохгүй.

2.10.Дараах тохиолдолд шинжилгээ хийлгэх этгээдийн эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоохдоо төрөлжсөн мэргэшлийн /сэтгэц, мансуурал судлал, эх барих, эмэгтэйчүүд, нүүр амны мэс заслын эмч гэх мэт/ эмч нарыг оролцуулан шинжээчийн бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийнэ:

2.10.1.сэтгэцийн болон донтох өвчтэй болсон;

2.10.2.жирэмслэлт таслагдсан;

2.10.3.нүүр, хүзүү болон биеийн ил харагдах хэсэг засрашгүй гэмтсэн;

2.10.4.хүний биед нөхөн сэргээх болон гоо сайхны мэс заслаар гадны биет суулгасны улмаас бүтэц, үйл ажиллагааны алдагдалд орсон.

2.11.Шинжилгээ хийх явцад нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай бол төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвөөр оношилгоо, шинжилгээ хийлгэх ба уг үзлэг, шинжилгээний тэмдэглэл, оношийг шинжилгээний баримт бичгийг үндэслэн шинжээч дүгнэлтээ гаргана.

2.12.Шинжилгээ хийлгэх этгээд шинжилгээ хийлгэхээс татгалзсан, эмнэл зүй тодорхой бус байх, шаардлагатай эмнэлгийн баримт бичиг, лабораторийн болон багажийн шинжилгээ хийгдээгүйн улмаас дүгнэлт гаргах боломжгүй болсон бол энэ тухай шинжилгээ хийлгэх шийдвэр гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

2.13.Шинжээч нь шинжилгээний явц, үр дүнг үндэслэн Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу шинжээчийн дүгнэлт гаргана.

2.14.Шинжээчийн дүгнэлтэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан зүйл тусгагдсан байна.

2.15.Шинжээч шинжилгээ хийлгэх этгээдийн биед үзлэг хийхдээ дуу, дүрсний бичлэг, гэрэл зургаар баримтжуулж болно.

Гурав. Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын хөнгөн, хүндэвтэр зэргийг тогтоох

3.1. Хүний эрүүл мэндэд хохирлын хөнгөн зэргийг тогтоохдоо дараах байдлыг тогтооно:

3.1.1.гэмтэл, түүнээс үүссэн эд, эрхтэний бүтэц, үйл ажиллагааны хямрал

нь эрүүл мэндийг дөрвөн долоо хоногоос доош буюу түр хугацаагаар сарниулсан;
3.1.2.ерөнхий хөдөлмөрийн чадвар бага хэмжээгээр буюу 5-10%-аар тогтонги алдагдсан.

3.2. Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын хүндэвтэр зэргийг тогтоохдоо дараах байдлыг тогтооно:

3.2.1.гэмтэл, түүнээс үүссэн эд, эрхтэний бүтэц, үйл ажиллагааны хямрал нь эрүүл мэндийг дөрвөн долоо хоногоос дээш буюу удаан хугацаагаар сарниулсан;

3.2.2.ерөнхий хөдөлмөрийн чадвар үлэмж хэмжээгээр буюу 15-30%-аар тогтонги алдагдсан.

Дөрөв. Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын хүнд зэрэг тогтоох

4.1.Амь насанд аюултай, хүний эрүүл мэндэд учирсан хүнд гэмтэлд дараах гэмтлүүд хамаарна:

4.1.1.гавлын хөндий рүү нэвтэрсэн шарх: тархи гэмтсэн эсэхийг харгалзахгүйгээр хуйх, зовхи, ухархай, хамар, хацар, чих, эрүү-чамархайн орчим зэрэг толгойн аль нэг хэсгээр гавлын хөндийд нэвтэрсэн шарх;

4.1.2.гавлын хүнхрээ ба суурь хэсгийн ил, далд хугарал: дух, зулай, чамархай, дагз зэрэг гавлын орой болон гавлын дунд, ар хонхор суурь ясны тархийг бүрхэж байгаа хэсгийн хугарал, заадлын салалт;

4.1.3.тархины хатуу хальсны дээрх, доорх цусан хураа, тархины аалзан бүрхүүл доорх цус харвалтын улмаас амь тэнссэн байдал илэрвэл;

4.1.4.тархины гэмтэл: тархины няцрал ба тархины эсийн урт сэртэнгийн /аксон/ тархмал гэмтлийн хүнд хэлбэр, гэмтлийн гаралтай ховдлын ба эдийн доторх цус харвалтаас амь тэнссэн байдал;

4.1.5.нугасны хөндийд нэвтэрсэн шарх: нугас гэмтээсэн эсэхийг харгалзахгүйгээр нугасны хөндийд нэвтэрсэн шарх;

4.1.6.хүзүүний нугалмын гэмтэл: хүзүүний нугалмын их биеийн хугарал, мултрал, аман, хатан хүзүүний аль нэг нум, шүдлэг сэртэн, бусад нугалмын хоёр талын нумны хугарал, хүзүүний олон нугалмын хугарал, хүзүүний нугалам хоорондын жийргэвч мөгөөрс гэмтсэнээс нугас дарагдсан гэмтэл;

4.1.7.сээр, бүсэлхийн нугалмын гэмтэл: сээр, бүсэлхийн нугалмын их биеийн хугарал, мултрал, нумны хугарлын улмаас нугасны үйл ажиллагаа алдагдсан, нугалам хоорондын жийргэвч мөгөөрс гэмтсэнээс нугас дарагдсан гэмтэл;

4.1.8.нугасны гэмтэл: нугас бүрэн ба бүрэн бус тасрах, няцрах гэмтэл;

4.1.9.том судасны гэмтэл: гол судас болон гүрээ, эгэмийн доорх, суга, бугалга, ташаа, гуя, тахимын тараагуур, хураагуур судасны урагдал, тасрал, зүсэгдэл, түүнчлэн гэмтлийн гаралтай цүлхэн үүсэх;

4.1.10.хүзүүний шарх: залгиур, төвөнх, цагаан мөгөөрсөн болон улаан хоолойд нэвтэрсэн шарх, түүнчлэн бамбай булчирхайг гэмтээсэн шарх;

4.1.11.төвөнх, бамбай, бөлзгөн, хутгуур, эвэр мөгөөрс, цагаан мөгөөрсөн хоолойн цагираг мөгөөрс, хэлэн доорх ясны хугарал;

4.1.12.цээжний гэмтэл: цээжний хэнхэрцгийн анатомын бүтэн байдал алдагдуулсан хоёр талын хоёр ба түүнээс дээш хавирганы хугарал, түүнчлэн нэг талын хоёр ба түүнээс дээш хавирга хоёр ба түүнээс дээш шугамаар хугарч “хавирганы хавхлаас” шинж үүсгэсэн гэмтэл;

4.1.13.цээжний хөндий рүү нэвтэрсэн шарх: дотор эрхтэнг гэмтээсэн цээжний хөндийд нэвтэрсэн шарх, түүнчлэн уг шархны улмаас үнхэлцгийн хөндий, голт, цээжний хөндийд цус, хий, агаар хуралдан үүний улмаас мэс ажилбар хийгдсэн бол;

4.1.14.хэвлийн хөндий рүү нэвтэрсэн шарх: дотор эрхтэнг гэмтээсэн хэвлийн хөндийд нэвтэрсэн шарх, түүнчлэн уг шархны улмаас хэвлийн хөндийд цус хуралдан үүний улмаас мэс ажилбар хийгдсэн бол;

4.1.15.цээж, хэвлий, аарцгийн хөндий болон хэвлийн гялтангийн гаднах эрхтний ил, далд гэмтэл: цээж, хэвлий, аарцгийн хөндийн эрхтэнүүд болон хэвлийн гялтангийн гаднах эрхтэнүүд бяцрах, тасрах, урагдах, үүний улмаас цээж, үнхэлцэг, хэвлийн хөндийд цус, хий, агаар хуралдсан гэмтэл;

4.1.16.хэвлийн гялтангийн арын зайд нэвтэрч, гялтангийн гаднах эрхтнүүдийг гэмтээсэн нуруу, ууцны доод хэсгийн шарх: нойр булчирхай, бөөр, бөөрний дээд булчирхай, шээлүүр, арван хоёр хуруу гэдэс, бүдүүн гэдэсний өгсөх, уруудах хэсгийг гэмтээсэн шарх;

4.1.17.бага аарцгийн хөндийн эрхтэнүүдийн гэмтэл: хярзан, үтрээ, шулуун гэдэсний ханын урагдал, шарх нь аарцгийн хөндий ба өөхлөг эд рүү нэвтэрсэн бол;

4.1.18.аарцаг ясны хугаралд: хоёр талын умдаг ясны болон суудал ясны урд хэсгийн буюу эрвээхэй хэлбэрийн хугарал нэг болон хоёр талын олон яс уулзах үеэр салсан аарцгийн ар хэсгийн хугарал, нэг болон хоёр талын умдаг, суудал ясны хугарал нь олон яс уулзах үеэр салахтай хавсарсан мальгены хугарал, нэг талын умдаг, суудал ясны хугарал нь эсрэг талын олон яс уулзах үеэр салахтай хавсарсан хугарал буюу воллюмын хугарал;

4.1.19. Энэ журмын 4.1.18-д зааснаас бусад хугарал нь хүнд хэлбэрийн шок, шээс дамжуулах сувгийн хальсархаг хэсэг тасрах зэрэгтэй хавсарсан бол;

4.1.20.рефлексийн бүсийн битүү гэмтэл: төвөнх, гүрээ буюу каротид синус, наран сүлжээ, гадна бэлэг эрхтэн орчмын гэмтлийн улмаас амь тэнссэн байдал үүссэн нь эмнэл зүй болон бүтэц зүйн шинжээр нотлогдсон;

4.1.21.өндөр ба нам хэм, хими, цахилгаан, туяаны үйлчлэлээр үүссэн гэмтэл: биеийн нийт гадаргуугийн 15 хувиас дээш талбайг хамарсан IIIБ, IV зэргийн, 20 хувиас дээш талбайг хамарсан IIIА зэргийн, 25 хувиас дээш талбайг хамарсан II зэргийн түлэгдэлт, хөлдөлт, эдгээрээс бага талбайтай боловч түлэгдэлтийн өвчин үүсгэсэн гэмтэл;

4.1.22.Биеийн нийт гадаргуугийн 50 хувь ба түүнээс дээш талбайг хамарсан I зэргийн түлэгдэлт, хөлдөлт, цус хуралтын улмаас амь тэнссэн байдал илэрвэл;

4.1.23.амьсгалын замын түлэгдэлт: дууны хөвч хавагнаж, завсар нь нарийссан түлэгдэлт;

4.1.24.туяаны үйлчлэлээр үүссэн өвчин: туяаны үйлчлэлээр үүссэн хүнд хэлбэрийн өвчин;

4.1.25.чөмөгт ясны ил хугарал: үүнд атгаал, дунд чөмөг, шаант ясны ил хугарал;

4.1.26.хоёр ба түүнээс дээш мөчдийн гурваас дээш чөмөгт ясны далд хугарал.

4.2.Амь насанд аюултай гэмтэл эмнэлгийн тусламжийн үр дүнд амь нас аврагдсан нь эрүүл мэндэд хохирлын зэргийг бууруулах, өөрчлөх үндэслэл болохгүй.

4.3.Амь тэнссэн байдал нь өөрөө аяндаа зохицуулагдах боломжгүй, эмнэлгийн яаралтай, иж бүрэн тусламж зайлшгүй шаардагддаг дараах хүндрэлүүд:

4.3.1.шокийн хүнд хэлбэр /III зэрэг/;

4.3.2.янз бүрийн шалтгаант ком /II-III зэрэг/;

4.3.3.цочмог болон их хэмжээний цус алдалт;

4.3.4.зүрх судасны цочмог дутагдлын хүнд хэлбэр;

4.3.5.тархины цусан хангамжийн алдагдлын хүнд хэлбэр;

4.3.6.элэг, бөөр, бөөрний дээд булчирхайн цочмог дутагдлын хүнд хэлбэр, нойр булчирхайн цочмог үхжил;

4.3.7.амьсгалын цочмог дутагдлын хүнд хэлбэр;

4.3.8.идээт үхжлийн байдал, тархины хальс, хэвлий болон цээжний гялтангийн идээт үрэвсэл, нэвчээс үүсэх;

4.3.9.мансууруулах /эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд хэрэглэдэг/, нойрсуулах, сэтгэц болон зүрх судасны тогтолцоонд нөлөөлөх эм бэлдмэл, архи, спиртийн төрлийн бодис, техникийн шингэн, хортой хүнд металл, хорт хий болон хоолонд хордох, амьсгал бүтэх, түүнчлэн захын цусны эргэлтийн хямралаас дотор эрхтэний шигдээст эмгэг, мөчдийн илжрэл /гангрэн/ болон тархи, уушигны судасны бүлэн, хий, өөхөн ба эдийн бөглөөдөс үүсэх, дулаан ба нарны цохилт, бээрэх, атмосферийн даралтын өвчин үүсэх, цахилгаанд цохиулах, аянганд ниргүүлэх, усгүйжих, тэжээлийн дутагдал, тураалд орох, хэт ачаалал авах.

4.4.Журмын 4.3-т заасан амь тэнссэн байдал нь шинжилгээ хийлгэх этгээдийн биед учирсан гэмтэлтэй шууд шалтгаант холбоотой нь эмнэл зүйн шинж, шинжилгээгээр нотлогдсон байна.

4.5.Тухайн гэмтлээс үүссэн үлдэц уршигт дараах гэмтэл хамаарна:

4.5.1.хараагүй, сонсголгүй, хэлгүй болох: үүнд хараагүй гэдэг нь хоёр нүд бүрмөсөн харахгүй буюу нүдний хараа 0,04 ба түүнээс доош буурах, хоёр чих бүрмөсөн сонсохгүй буюу хамгийн ойр зайнаас /3-5см-т/ ердийн яриаг сонсохгүй

болох, өөрийн бодол санааг бусдад үгээр илэрхийлж чадахгүй болох;

4.5.2. зарим эрхтэнгүй болох, эсхүл тэдгээрийн үйл ажиллагаа бүрэн алдагдах: үүнд гаргүй, хөлгүй болох буюу гар сарвуунаас, хөл тавхайнаас дээш тасрах, эсхүл тэдгээрийн үйл ажиллагаа бүрэн алдагдах, түүнчлэн хурьцах, үр тогтоох, жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй болох, нэг төмсөг, хөхгүй болох зэрэг үлдэц уршигтай болох;

4.5.3. жирэмслэлт таслагдах: үүнд гэмтлийн улмаас жирэмслэлтийн хугацаа үл хамааран дутуу төрөх, ураг зулбах, ураг амьгүй болох;

4.5.4. нүүр засаршгүй гэмтэж, нүүрний төрх алдагдах: үүнд нүүрэнд учирсан гэмтлийн улмаас үүссэн сорви нь тухайн хүний нүүрний төрхийг илтэд өөрчилсөн, нүүрний тэгш хэмийг алдагдуулсан, нүдний зовхи, аньсага, хамрын самсаа, уруулын хэлбэрийг алдагдуулсан буюу арьсны түвшингээс дээш овойж хатуурч, эсхүл доош татагдаж хонхойсон сорви үүссэн, нүүрний дүр төрхийг сэргээх мэс засал зайлшгүй хийгдэж засрах боломжтой гэмтэл; нүүрний дээд хязгаар нь хуйхны үстэй хэсэг хажуу нь чихний дэлбэнгийн араар, эрүүний салааны арын ирмэг доод хязгаар нь эрүүний булан, эрүүний доод ирмэг болно.

4.5.5. сэтгэцийн болон донтох өвчтэй болгох: гэмтлийн шалтгаант уналт таталт, тэнэгрэл, токсикомани, наркомани.

4.6. Хөдөлмөрийн ерөнхий чадвар тогтонги байдлаар их хэмжээгээр алдагдах гэмтэлд дараах хугарал, гэмтэл хамаарна:

4.6.1. сүүж ясны тогооны зөрөөтэй хугарал;

4.6.2. атгаалын үен доторх /толгой/, үе орчмын /анатомийн хүзүү, төвгөрийн доорх ба төвгөр дайрсан хугарал/, дунд чөмөгний толгой, хүзүүний үен доторх хугарал /толгой хүзүүний хугарал/;

4.6.3. тохойн үе үүсгэгч яснуудын ил хугарал;

4.6.4. өвдөгний үе үүсгэгч яснуудын /тойгноос бусад/ ил хугарал;

4.6.5. шагайн үеийг үүсгэхэд оролцох шаант ясны гадна ба дотор хавчаар ясны ил хугарал нь шагайн үений бүрэн мултралтай хавсарсан гэмтэл;

4.6.6. мэргэжлийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалт.

4.7. Энэ журамд зааснаас бусад нугасны мэдрэлийн ёзоор цочирч, рефлексээр түр зуур хуниас булчин агших, сулрах, зүрх, амьсгалын хэм алдагдах хямрал, “хавирганы хавхлаас” шинж илрээгүй, цээжний гялтанг гэмтээгээгүй нэг ба түүнээс дээш хавирганы хугарал, ухархайн дээд хана, духны хөндийн өмнөд ханын хугарал, гавлын орой ясны гадна ялтасны цууралт, нүүрний яснуудын хугарал, эрхтэн доргих, цээж, хэвлийн хөндийн эрхтний хальсанд цус харвах, хальс язрах, няцрах гэмтэл нь хүний биед учирсан хүнд гэмтлийн зэрэгт хамаарахгүй.

4.8. Хүний эрүүл мэндэд учирсан хүнд зэргийн хохиролд амь насанд аюултай гэмтэл, амь тэнссэн байдал, гэмтлээс үүссэн үлдэц уршиг, ерөнхий хөдөлмөрийн чадвар их хэмжээгээр (35-100 хувь) тогтонги алдагдсан шалгуур шинж бүхий гэмтлүүд хамаарна.

Тав. Ерөнхий хөдөлмөрийн чадварын тогтонги алдалтыг тогтоох

5.1. Ерөнхий хөдөлмөрийн чадварын тогтонги алдалтыг дараах байдлаар тогтооно:

№	Гэмтэл, гэмтлийн дараах үлдэц уршиг		Ерөнхий хөдөлмөрийн чадвар алдалт /Хувь/	
			Баруун	Зүүн
Нэг. Төв ба захын мэдрэлийн эрхтэн тогтолцоо				
Тархи ба гавлын хүнд гэмтлийн дараах үлдэц уршиг:				
1	1	Мөчдийн хүч, хөдөлгөөн нэлээд хэмжээгээр алдагдах, огцом тэнцвэр алдагдах, сард 1-с дээш уналт таталт үүсэх, сэтгэхүйн чадвар нэлээд муудах.	75	
	2	Ой ухаан мэдэгдэхүйц муудах, саажилт үүсэх, ойр ойрхон унаж татах /7 хоногт нэгээс дээш удаа/, таних үйл ажиллагаа алдагдах /агнози/, тэнцвэр, хөдөлгөөний уялдаа алдагдах, бага тархи болон тэнцвэрийн аппаратын үйл ажиллагаа алдагдах, хэлгүй болох.	100	
Тайлбар: Дээрх шинжүүдээс нэг үлдэц илэрч байвал хөдөлмөрийн чадвар тогтонги алдалтыг үнэлж тогтооно.				
Гавал тархины хүнд гэмтлийн дараах үлдэц уршиг:				
2	1	Тэнцвэр хөнгөн хэлбэрээр алдагдах, булчингийн тонус бага хэмжээгээр ихсэх, мөчдийн хүч хөнгөн хэлбэрээр багасах, мэдрэх чанар бага зэрэг алдагдах, ганц нэг уналт таталт, хөдөлгөөний алдагдал дунд зэрэг.	30	
	2	Тэнцвэр дунд зэрэг алдагдах, булчингийн тонус ихсэх, мөчдийн хүч дунд зэрэг сулрах, хөдөлгөөний алдагдал их бус зэрэг, цөөн уналт таталт /жилд 2-3 удаа/.	45	
	3	Тэнцвэр эрс алдагдах, булчингийн тонус их хэмжээгээр ихсэх, мөчдийн хүч сулрах, ой ухаан муудах, олон уналт таталт /жилд 4-10 удаа болох/.	60	
Тайлбар: Хөдөлмөрийн чадварын тогтонги алдалтыг тогтоохдоо дээрх шинжүүдээс хоёр илрэх эсвэл уналт таталт илэрсэн байх шаардлагатай.				
Гавал тархины гэмтэл:				
3	1	Төв мэдрэлийн системийн талаас ямар нэгэн эмгэг өөрчлөлт илрээгүй.	0	
	2	Мэдэгдэхүйц вегататив өөрчлөлт илэрсэн /гарын хуруу, зовхины чичиргээ, шөрмөсний рефлекс ихэссэн, вазомоторын өөрчлөлттэй/.	10	
	3	Голомтот өөрчлөлт илрэх /анизокори/, хоёр аньсага өөр болох, хэл мурийх, хамар уруулын нугалаас гөлийх, нистагм үүсэх.	15	
Тархи доргилтын дараах үлдэц:				
4	1	Төв мэдрэлийн системээс бодит ба вегататив шинжүүд илрэх /аньсага өөр болох, нистагм илрэх, хэл мурийх, дистони, шөрмөсний рефлекс ихсэх, хөлрөх, Ромбергийн байрлалд тогтворгүй байх.	5	
	Тайлбар: 1. Дээрх тархи доргилтын өөрчлөлтүүдийг үнэлэхдээ тархи доргилт онош нь объектив шинж тэмдэг ба анх эмнэлгийн байгууллагад очиход нь бүрэн дүүрэн оношилсон тохиолдолд хэрэглэнэ. 2. Зөвхөн субъектив шинж тэмдэг дээр үндэслэн хохирогчийн зовиур шаналгаан дээр тулгуурлан онош тавихгүй. 3.Төв мэдрэлийн үйл ажиллагааны хямралтай өвчинтэй /тархины наалданги,			

	уналт таталт, тархины цусан хангамжийн алдал, эсвэл урьд нь тархины хүнд гэмтэл авч байсан тохиолдлуудад тархи доргилтын хөдөлмөр чадвар алдалтыг үнэлэхгүй/.		
5	Хүзүү, цээж, нурууны орчмын нугасны гэмтэл нь:		
	1	Аарцгийн хөндийн эрхтэн болон мөчдийн хөдөлгөөний алдагдалгүй хөнгөн хэлбэрээр шөрмөсний мэдрэхүй хөнгөн хэлбэрээр алдагдах.	15
	2	Аарцгийн хөндийн эрхтний үйл ажиллагаа үл ялиг хэмжээгээр өөрчлөгдөх, хөдөлгөөн үл ялиг хэмжээгээр өөрчлөгдөх, булчингийн хатингаршил, шөрмөсний рефлекс, мэдрэхүйн бага хэмжээний өөрчлөлт, тэжээл үл ялиг хэмжээгээр алдагдах.	40
	3	Мэдрэхүйн үлэмж өөрчлөлт, хөдөлгөөний өөрчлөлт, нэг мөчний бүрэн саажилт эсвэл 2 мөчний хөнгөн саажилт, аарцагны хөндийн эрхтний үйл ажиллагаа алдагдах, тэжээл үлэмж хэмжээгээр алдагдах, спазм илрэх.	60
	4	Мөчдийн хөдөлгөөн, мэдрэхүй гүн алдагдах /парапарез, тетрапарез/ аарцагны хөндийн эрхтнүүдийн үйл ажиллагааны алдагдал гүнзгий илрэх, тэжээлийн алдагдал гүнзгий, зүрх судас амьсгалын үйл ажиллагааны алдагдал үүсэх, спазм гүнзгий илрэх.	100
6	“Адуун сүүл”-ний шинж :		
	1	Доод мөчдийн хөдөлгөөн болон рефлексийн өөрчлөлтгүй мэдрэхүй хөнгөн зэргээр алдагдах, тэжээл болон аарцагны хөндийн эрхтний үйл ажиллагааны алдагдалгүй, зөвхөн өвдөлт илрэх.	5
	2	Доод мөчдийн хөдөлгөөн, шөрмөсний рефлекс болон мэдрэхүйн хөнгөн зэргийн алдагдал, мөчдийн хөдөлгөөний алдагдал үгүй булчингийн хөнгөн хэлбэрийн гипотрофи, аарцагны хөндийн эрхтний үйл ажиллагааны алдагдал үгүй байх.	15
	3	Мэдрэхүйн алдагдал нэлээд хэмжээгээр илрэх, гипералгези, рефлексийн нумын алдагдал /рефлекс буурах эсвэл үгүй болох/, мэдрэлжүүлэлтийн хэсэгт булчингийн хатингаршил ихээр үүсэх, ургал мэдрэлийн хямрал бага хэмжээгээр үүсэх /хөл хөрөх/, аарцгийн эрхтний үйл ажиллагааны алдагдал үүсэх.	40
	4	Мэдрэхүй ихээр алдагдах, мөчид хөдөлгөөнгүй болох /нэг ба хоёр хөлний илэрхий саажилт/ аарцгийн эрхтний үйл ажиллагааны алдагдал ихээр хямрах, тэжээлийн хямрал /шархлаа, цианоз, хаван үүсэх/.	60
	5	Доод мөчдийн мэдрэхүй болон хөдөлгөөн бүрэн алдагдах /доод мөчдийн бүрэн саажилт/, аарцгийн эрхтний үйл ажиллагааны алдагдал бүрэн алдагдал, тэжээлийн гүнзгий хямрал /тэжээл алдалтын шархлаа, холголт үүсэх/.	100
7	1	Гэмтлийн шалтгаант мэдрэлийн ёзоорын эмгэгшил.	5

8	Гурвалсан мэдрэл, нүүр, хэлэн доорхи мэдрэлийн захын хэсгийн гэмтэл, үйл ажиллагааны алдагдалтай:		5
	1	Бага хэмжээгээр.	5
	2	Нэлээд хэмжээгээр.	15
	3	Их хэмжээгээр.	25
9	Хүзүү, мөрний сүлжээ болон тэдгээрийн судлын гэмтэл, үйл ажиллагааны алдагдал үүссэн бол:		
	1	Мэдрэхүй болон рефлекс алдагдал, хөдөлгөөн алдагдал үгүй байх, булчингийн хатингаршил, саажилт, контрактур үүсэх.	5
	2	Мэдрэхүй болон рефлекс алдагдал, хөдөлгөөн алдагдалт, булчингийн хатингаршил, саажилт, контрактур үүсэх.	15
	3	Гарны хөдөлгөөн хязгаарлалт нэлээд их, булчингийн хатингаршил, хүч, мэдрэхүй нэлээд сулрах.	25
	4	Дээд мөчдийн хөдөлгөөн ихээр алдагдах, булчингийн хатингаршил, хүч, мэдрэхүйн гүнзгий алдагдал.	40
5	Гар хөдөлгөөгүй болох, мэдрэхүй үгүй болох, тэжээлийн гүнзгий хямрал / тэжээл алдалтын шарх/.	70	
10	Бүсэлхий, ууцны сүлжээ болон тэдгээрийн суудлын гэмтэл үйл ажиллагааны алдагдал үүссэн бол:		
	1	Мэдрэхүй болон рефлекс алдагдал, хөдөлгөөн алдагдал үгүй байх, булчингийн хатингаршил, саажилт, контрактур үүсэх.	5
	2	Мэдрэхүй болон рефлекс алдагдал, хөдөлгөөн алдагдалт, булчингийн хатингаршил, саажилт, контрактур үүсэх.	15
	3	Хөлний хөдөлгөөн хязгаарлалт нэлээд их, булчингийн хатингаршил, хүч, мэдрэхүй нэлээд сулрах.	25
	4	Доод мөчдийн хөдөлгөөн ихээр алдагдах, булчингийн хатингаршил, хүч, мэдрэхүйн гүнзгий алдагдал.	40
5	Гар хөдөлгөөгүй болох, мэдрэхүй үгүй болох, тэжээлийн гүнзгий хямрал / тэжээл алдалтын шарх үүсэх/.	70	
Хоёр: Харааны эрхтэн тогтолцоо			
11	Харааны зохицол саажих:		
	1	1 нүдний.	15
	2	2 нүдний.	30
12	Хараа аль нэг чиглэлд таллаж саажих /баруун, зүүн, дээд, доод тал/		30
13	Харах талбай хоёр талаасаа нарийсах:		
	1	1 нүдний харах талбай нэг талаасаа 60 хэм хүртэл нарийсах.	10
	2	30 хэм хүртэл нарийсах.	20
	3	5 хэм хүртэл нарийсах.	30
	4	2 нүдний харах талбай тал талаасаа 60 хэм хүртэл нарийсах.	20
5	30 хэм хүртэл нарийсах.	40	

	6	5 хэм хүртэл нарийсах.	60
	Тайлбар: Гэмтлийн улмаас харааны чадвар болон харах талбай хоёр талаасаа нарийсахад хөдөлмөрийн чадварын тогтонги алдагдлын хувь нэг нүдэнд 35%-с ихгүй байна.		
	Харах талбай нэг талаасаа нарийсах:		
14	1	1 нүдний харах талбай нэг талаасаа 50 хэм хүртэл нарийсах	5
	2	25 хэм хүртэл нарийсах.	10
	3	5 хэм хүртэл нарийсах.	15
	4	2 нүдний харах талбай нэг талаасаа 50 хэм хүртэл нарийсах	10
	5	25 хэм хүртэл нарийсах.	20
	6	5 хэм хүртэл нарийсах.	30
	Зовхи буух /птоз/, нүдний булчин саажих болон нүд анихад саад болохуйц зовхины сорви, наалдац үүсэх:		
15	1	1 нүдний зовхи хүүхэн харааны талыг хаасан байх /дунд зэрэг/.	10
	2	1 нүдний зовхи хүүхэн харааг бүтэн хаасан байх /хүнд зэрэг/	20
	3	2 нүдний зовхи хүүхэн харааны талыг хаасан байх /дунд зэрэг/.	25
	4	2 нүдний зовхи хүүхэн харааг бүтэн хаасан байх /хүнд зэрэг/.	50
	Нүд лугшиж бүлтийх:		
16	1	1 нүд бага хэмжээгээр бүлтийх /хөнгөн зэрэг/.	20
	2	үлэмж хэмжээгээр бүлтийх /дунд зэрэг/.	30
	3	их хэмжээгээр бүлтийх /хүнд зэрэг/.	40
	4	2 нүд бага хэмжээгээр бүлтийх /хөнгөн зэрэг/.	35
	5	үлэмж хэмжээгээр бүлтийх /дунд зэрэг/.	60
	6	их хэмжээгээр бүлтийх /хүнд зэрэг/.	85
	Нүдний зовхины салст ба эвэрлэгийн архаг үрэвсэл, зовхи эргэлт харааны бууралтгүй байх:		
17	1	1 нүдний.	5
	2	2 нүдний.	10
	Солонгон болон судаслаг бүрхүүлийн үрэвсэл харааны бууралтгүй байх:		
18	1	1 нүдний.	10
	2	2 нүдний.	20
	Нулимсны замын үйл ажиллагаа алдагдах:		
19	1	Нулимсны суваг, хүүдий сорвижиж битүүрэх.	10
	2	Гэмтлийн дараах нулимсны хүүдийн үрэвсэл /дакриоцистит/.	20
20	Нүдний алимын эвэрлэг бүрхүүлийн совижил, колобома /солонгон бүрхүүлийн эвдрэл, хүүхэн харааны хэлбэр алдагдал/, гемофтальм, нэг нүдний болрын хазайлт харааны бууралтгүй байх.		5
	Нүд хараагүй болох:		
21	1	Хараатай байсан 1 нүд бүрэн хараагүй болох.	65
	2	Хараатай байсан 2 нүд бүрэн хараагүй болох.	100
22	Гэмтлийн улмаас хараагүй байсан нүдийг авах.		5
23	Ухархайн гавлын хөндийрүү ороогүй хугарлын дараах үлдэц:		

	1	Ухархай гэмтсэн боловч нүдний булчин гэмтээгүй, нүдний алим суулт өгөөгүй байх.	10			
	2	Нүдний булчин гэмтсэнээс нүдний алим суулт өгөх.	20			
24	Гэмтлийн улмаас нүдний хараа буурах:					
24	Гэмтлийн улмаас нүдний хараа буурах					
	№	Гэмт- лийн өмнөх хараа	Гэмтлийн дараах хараа			ЕХЧА /хувь/
			Америк оптотип	6m (Англи) оптотип	Орос, Хятад оптотип	
			20/20	6/6	1.0	
	1	1.0	20/22	6/6.6	0.9	5
			20/25	6/7.5	0.8	5
			20/28	6/8.5	0.7	5
			20/32	6/9.5	0.6	5
			20/40	6/12	0.5	10
			20/50	6/15	0.4	10
			20/63	6/19	0.3	15
			20/100	6/30	0.2	20
			20/200	6/60	0.1	25
			20/250-20/500 20/630	6/75-6/150 6/190	0.09-0.04 0.03 ба түүнээс бага	30 35
	2	0.9	20/25	6/7.5	0.8	5
			20/28	6/8.5	0.7	5
			20/32	6/9.5	0.6	5
20/40			6/12	0.5	10	
20/50			6/15	0.4	10	
20/63			6/19	0.3	15	
20/100			6/30	0.2	20	
20/200			6/60	0.1	25	
20/250-20/500 20/630			6/75-6/150 6/190	0.09-0.04 0.03 ба түүнээс бага	30 35	
3			0.8	20/28	6/8.5	0.7
	20/32	6/9.5		0.6	5	
	20/40	6/12		0.5	10	
	20/50	6/15		0.4	10	
	20/63	6/19		0.3	15	
	20/100	6/30		0.2	20	
	20/200	6/60		0.1	25	
	20/250-20/500 20/630	6/75-6/150 6/190		0.09-0.04 0.03 ба түүнээс бага	30 35	
4	0.7	20/32	6/9.5	0.6	5	
		20/40	6/12	0.5	5	
		20/50	6/15	0.4	10	
		20/63	6/19	0.3	10	
		20/100	6/30	0.2	15	
		20/200	6/60	0.1	20	
		20/250-20/500 20/630	6/75-6/150 6/190	0.09-0.04 0.03 ба түүнээс бага	25 30	

	5	0.6	20/40 20/50 20/63 20/100 20/200 20/250-20/500 20/630	6/12 6/15 6/19 6/30 6/60 6/75-6/150 6/190	0.5 0.4 0.3 0.2 0.1 0.09-0.04 0.03 ба түүнээс бага	5 5 5 10 15 20 25	
	6	0.5	20/50 20/63 20/100 20/200 20/250-20/500 20/630	6/15 6/19 6/30 6/60 6/75-6/150 6/190	0.4 0.3 0.2 0.1 0.09-0.04 0.03 ба түүнээс бага	5 5 5 10 15 20	
	7	0.4	20/63 20/100 20/200 20/250-20/500 20/630	6/19 6/30 6/60 6/75-6/150 6/190	0.3 0.2 0.1 0.09-0.04 0.03 ба түүнээс бага	5 5 10 15 20	
	8	0.3	20/100 20/200 20/250-20/500 20/630	6/30 6/60 6/75-6/150 6/190	0.2 0.1 0.09-0.04 0.03 ба түүнээс бага	5 5 10 20	
	9	0.2	20/200 20/250-20/500 20/630	6/60 6/75-6/150 6/190	0.1 0.09-0.04 0.03 ба түүнээс бага	5 10 15	
	10	0.1	20/250-20/500 20/630	6/75-6/150 6/190	0.09-0.04 0.03 ба түүнээс бага	5 15	
	11	0.1-ээс бага	0.0	0.0	0.0	10	
Гурав. Сонголын эрхтэн тогтолцоо							
25	1	Гэмтлийн улмаас тэнцвэрийн үйл ажиллагаа алдагдах.				15	
26	Чихний дэлбэн тасрах:						
	1	Дэлбэнгийн гуравны нэг хүртэлх хэсэг тасрах.				5	
